



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 1/235

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Тайшир, Баян-Уул сумын Засаг даргын тамгын газар, иргэдэд үйлчлэх мэдээллийн төв ашиглалтад орсонтой холбогдуулан төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог сайжруулж техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 10,600,000 (арван сая зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

